

농작업 안전 자가점검 체크리스트 (몽골어)

ХАА-н хөдөлмөрийн аюулгүй байдал
Өөрийгөө шалгах хуудас



* Хэрэглэгч танаа

1. Энэхүү өөрийгөө шалгах хуудасны асуумжийг анхааралтай уншиж, “(O) Тийм”, “(X) Үгүй” хариултыг сонгон хариулахын зэрэгцээ, сайжруулах засах шаардлагатай зүйл байвал тодорхойлно уу.
2. Ухаалаг утсаараа QR кодыг уншуулна уу. Видео хичээлээс аюулгүй байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.
3. Хавтсан дээр байгаа QR кодыг уншуулбал өөрийгөө шалгах хуудсыг татах боломжтой веб хуудас руу шилжин очно. Өөрийгөө шалгах хуудсыг тогтмол ашиглаж хэвшээрэй.

[Ухаалаг утасны камер ашиглан QR кодыг хялбар уншуулах арга]



1 ХАА-н техник хэрэгсэл



[Хувцаслалт]


- Машин төхөөрөмжинд орооцолдож татагдахаас сэргийлэх, биеийн аль нэг хэсэг хавчуулагдах ослоос сэргийлэх үүднээс хувцасны ханцуй, өмдний шуумаг зэрэг сул биш байна ☐ ☐
- Гүйцэтгэж буй ажилд тохирсон ажлын хувцас, малгай, хамгаалалтын гутал, бээлий зэрэг хамгаалах хэрэгсэл өмсөж хэрэглэнэ. ☐ ☐

[Аюулгүй байдлыг шалгах]

- Техник хэрэгслийг тогтмол шалгаж, засаж, ашиглахын өмнө сэлбэг хэрэгсэл бүрэн бүтэн байгаа эсэхийг, ослын унтраалга ажиллаж байгаа эсэхийг шалгана. ☐ ☐
- Эргэлддэг хэсэгт болон осол гарах эрсдэлтэй хэсэгт хамгаалалтын хаалт таглаа юм уу аюулгүйн төхөөрөмж суурилуулна. ☐ ☐
- Эргэлдэн хөдөлдөг тариалангийн техник хэрэгслийг шалгах, засахын өмнө эхлээд заавал моторыг нь унтраана. ☐ ☐

[Аюулгүй жолоодлого]

- Налуу зам, талбайн давчуу замаар явах, чиглэл солих үедээ хурдаа бууруулна. ☐ ☐
- Шөнө болон цаг агаарын таагүй нөхцөлд хөдөлгөөнд оролцох магадлалтай тул шөнийн цацруулагч, гэрэл зэрэг төхөөрөмжөө шалгана. ☐ ☐
- Машиныг зогсоолд тавихдаа моторыг заавал унтрааж тоормосыг буулгана. ☐ ☐
- Зам дээр замын хөдөлгөөний дүрмийг заавал баримтална. ☐ ☐
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоо хэзээ ч барихгүй. ☐ ☐



2 Халуун өдөр / Нартай өдөр



- Нартай өдөр гадаа удаан хугацаагаар ажиллахдаа нарны тос түрхэнэ. Малгай, урт ханцуйтай цамц өмд зэрэг нарнаас хамгаалах зориулалт бүхий хувцас өмсөнө. ☐ ☐
- Хэт халуун цагаар (өдрийн 12:00–17:00 цаг) ажлаа завсарлана. ☐ ☐
- Ажиллаж байхдаа боломжтой үед тааруулан сэрүүн газар ойр ойрхон амарна. ☐ ☐
- Биедээ байнга ус байлгаж, ойр ойрхон ууна. ☐ ☐
- Шингэн дутагдах, нарших зэрэг эмгэгээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах арга мэднэ. ☐ ☐
- Аль болох хоёр хоёроороо нэг баг болж ажиллана. ☐ ☐
- Зуны улиралд өдрийн цагаар биш үүрээр юм уу үдээс хойш оройн цагаар ажиллана. ☐ ☐

3 Яаралтай тусламж



- Гэнэтийн осол аюулын үед яаралтай тусламж үзүүлэх аргыг мэднэ. ☐ ☐
- Яаралтай тусламжийн хайрцгийг шууд ашиглах боломжтой газар байрлуулах юм уу ажлын үеэр авч явдаг. ☐ ☐

4 Аюулгүй байдлын талаарх мэдлэг




[Аюулгүйн даатгал]

- ХАА-н ажилтны аюулгүйн даатгал болон ХАА-ын техник хэрэгслийн нэгдсэн даатгалд даатгуулна. ☐ ☐

[Сургалт/дадлага]

- ХАА-н үйл ажиллагаатай холбоотой аюултай болон эрсдэлт хүчин зүйл, аюулгүй ажиллагааны менежментийн сургалтанд сууна. ☐ ☐



5 Хортон шавжны хор



[Хувийн хамгаалах хэрэгсэл]

- Хортон шавжны хор цацахдаа хамгаалах комбинзон, маск, нүдний шил, малгай, бээлий, хамгаалах түрийтэй гутал зэргийг өмсөнө. ☐ ☐
- Хортон шавжны хор цацахын өмнө, хорыг найруулахдаа ч гэсэн маск, хамгаалалтын шил, бээлий зэргийг өмсөж хэрэглэнэ. ☐ ☐
- Хувийн хамгаалах хэрэгсэл ашиглахын өмнө бүтэн эсэхийг шалгаж, өмссөний дараа энгийн хувцаснаас тусад нь угааж цэвэрлэсний дараа хадгална. ☐ ☐
- Шавжны хор цацахад өмсдөг хувцасны өмдний шуумгийг урт түрийтэй гуталны гадуур гаргаж өмсөнө. ☐ ☐

[Аюулыг мэдээлэх]

- Шавжны хор цацаж байхдаа болон цацсаны дараа 'Хор цацсан талбай' гэдгийг мэдээлсэн самбар байрлуулна. ☐ ☐

[Аюулгүй ажиллагааны менежмент]

- SS машины суудал нь хор цацах цоргоноос хол, аюулгүй зайд байх шаардлагатай ☐ ☐
- Хор цацсаны дараа тэр даруй савангаар савандаж усанд орно. ☐ ☐
- Хор цацсан талбайд тодорхой хугацааны турш орж болохгүй. ☐ ☐
- Хэрэв шавжны хор уусан бол 119-т мэдэгдэж, эмчид хорны нэрийг хэлж өгнө. ☐ ☐

[Шавжны хор хадгалах/устгах]

- Шавжны хорыг цоожтой хайрцагт, нэр төрлөөр нь ангилан хийнэ. ☐ ☐
- Хэрэглэсэн хорны шил сав, үлдэгдлийг тусгай газар хадгалж байгаад тусад нь хаяна. ☐ ☐
- Шавжны хор найруулах үедээ үлдсэн хорыг өөр саванд хийж хадгалахгүй. ☐ ☐



6 Өндрөөс унах/Халтирах/Бүдрэх



[Ажлын орчин]

- Шал халтиргаатай эсэх, тээглэж унах босго байгаа эсэх, хонхор хотгор хэсэг байгаа эсэхийг шалгаж эрсдэл аюулыг арилгана. ☐ ☐
- Ачааны тэрэг, явган хүн хоёр зөрж явахад аюулгүй байхаар замыг чөлөөлнө. ☐ ☐

[Ажлын гутал]

- Халтирахаас хамгаалсан тусгай ажлын гутал өмсөнө. ☐ ☐
- Халтирахаас хамгаалж гутлын улыг байнга цэвэрлэнэ. ☐ ☐

[Эвхдэг шат]

- Хэрэглэхээсээ өмнө шатны бүрэн бүтэн эсэхийг шалгана. ☐ ☐
- Хамгаалалтын малгай, хувийн хамгаалах хэрэгсэл, хамгаалалтын гутал заавал өмсөнө. ☐ ☐
- Шатаа тэгш хатуу хавтгай дээр байрлуулна. ☐ ☐
- Шат, газар хоёр хоорондоо 75 хэмийн налуутай байхаар байрлуулна. ☐ ☐
- А үсэг хэлбэртэй шатанд дэлгэгдэх юмуу эвхэгдэж унахаас хамгаалсан, дунд нь түгжих зориулттай түгжээ хийнэ. ☐ ☐
- Эвхдэг шатны хамгийн дээд талын 3 гишгүүрээс доош бусад гишгүүр дээр зогсож ажиллана. ☐ ☐
- Хоёр хөл, нэг гар, эсвэл нэг хөл хоёр гараараа шаттайгаа харилцаж ажиллана. ☐ ☐

[Жимсний талбай]

- Эвхдэг шат юм уу өргөгчтэй машин дээр ажиллахдаа 2, 2-оороо ажиллана. ☐ ☐
- Эвхдэг шатыг налуу газар тавьж ажиллахдаа намхнаас өндөр газар луу байршуулна. ☐ ☐
- Өргөгчтэй машин дээр ажиллахдаа машин хөмрөхөөс сэргийлнэ. ☐ ☐
- Өргөгчтэй машин дээр ажиллахдаа даацыг хэтрүүлэхгүй. ☐ ☐



7 Булчингийн тогтолцооны эмгэг



[Сунгалтын дасгал]

- Ажил эхлэхийн өмнө, хийж байхдаа, хийж дуусаад сунгалтын дасгал хийнэ.

☐ ☐

[Туслах төхөөрөмж]

- Бөгтөгнөх юм уу явган сууж ажиллах байдлаас аль болох зайлсхийж туслах төхөөрөмж ашиглана.
- Нэг хөдөлгөөн давтан хийдэг бол тохойн хэрийн өндөртэй эсвэл түүнээс арай намхан тавцан байрлуулж түүн дээр ажлаа хийнэ.
- Сандал дээр сууж ажилладаг бол түшлэгтэй, тохиромжтой өндөр бүхий сандал ашиглана.

☐ ☐
☐ ☐
☐ ☐



[Хүнд ачаа]

- Хүнд ачаа зөөхдөө тэрэг гэх мэт дугуйтай тэрэг, тавцан ашиглана.
- Ачаа зөөх зайг аль болох багасгаж, жин, хэмжээ зэргийг нь багасгаж олон удаа тасалж зөөнө.
- Шалан дээр байгаа ачааг өргөхдөө нуруугаа эгцлэн өвдгөө нугалаад өргөх гэж байгаа ачаагаа биедээ наагаад хөлнийхөө хүчээр өргөнө.

☐ ☐
☐ ☐
☐ ☐

[Ажиллах арга барил]

- Биеийн өөр өөр хэсэгт ачаалал өгдөг хөдөлгөөнүүдийг ээлжлэн хийж биед ирэх ачааллыг бууруулна.
- Үдаан ажиллаж урт амарснаас богино хугацаагаар ажиллаж ойр ойрхон амарна.

☐ ☐
☐ ☐


8 Байгууламж, орчин нөхцөл



[Зам]

- Зам өргөн, эмх цэгцтэй цэвэрхэн байна.
- Шаттай хэсгийг булан босгогүй налуу болгож янзална.

☐ ☐

☐ ☐

[Гэрэлтүүлэг]

- Агуулах, малын хашаа, ажлын талбар, шат зэрэг хэсэгт хангалттай тод гэрэл байрлуулна. (Энгийн ажлын үед 150 (lux)–ээс дээш, нарийн ажиллагааны үед 300 (lux)–аас дээш)
- Гэрлийн шилийг хийх, авах үед цахилгааныг салгаж, хамгаалалтын хэрэгсэл өмсөнө.

☐ ☐

☐ ☐

[Эмх цэгц]

- Ажлын багаж хэрэгслийг олоход амархан газар цэгцэлж тавина.
- Ажлын талбайг ажиллахад тохиромжтой байхаар эмх цэгцтэй байлгана.

☐ ☐

☐ ☐

[Ариун цэвэр]

- Мөөгөнцөр, бичил биетнээс хамгаалж байнга цэвэр цэмцгэр байлгана.
- Ажлын тав тухтай орчныг бүрдүүлэхийн тулд ойр ойрхон агааржуулна.

☐ ☐



☐ ☐

[Аюултай байр байгууламж]

- Аюултай байр байгууламж(үр тарианы босоо агуулах, бордооны агуулах, химийн бодисын агуулах, малын хашаа)–ийн хаалгыг гаднын хүн болон хүүхэд орохоос сэргийлж байнга түгжинэ.
- Аюултай байр байгууламжийн үүдэн дээр ‘Аюултай’ гэсэн тэмдэг байрлуулна.

☐ ☐

☐ ☐



9 Малын хашаа



[Хувцаслалт/хувийн хамгаалах хэрэгсэл]

- Ажиллахад тохиромжтой хамгаалалтын малгай, халтирахаас хамгаалсан гутал, тоосноос хамгаалах маск, хамгаалалтын нүдний шил зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл өмсөнө.
- Тарианы зүүнд хатгуулахаас хамгаалж бээлийн өмсөнө.
- Өтөг бууц боловсруулах байранд ажиллахдаа хүчилтөрөгчтэй маск, хийн дохиолол зэрэг аюулгүйн хэрэгсэл ашиглана.

☐ ☐

[Цахилгаан]

- Цахилгаан утасны холболтуудыг тогтмол шалгана.
- Мал амьтнаас үүдэлтэй цахилгаан хэрэгслийн гэмтэл гарахаас сэргийлж байнга шалгана.
- Цахилгаанд цохиулахаас сэргийлж газардуулагч суурилуулна. Ажиллаж байгаа эсэхийг тогтмол шалгана.

☐ ☐
☐ ☐
☐ ☐



[Ажлын орчин]

- Агааржуулагчийн бүрэн бүтэн ажиллагааг тогтмол шалгана.
- Өтөг бууц боловсруулах байрны гадна 'Анхаар' тэмдэг байрлуулж, ажлын үеэр амьсгал боогдох ослоос сэргийлж, аюулгүйн ажиллагааны дүрмийг чанад мөрдөн ажиллана.
- Хавчуулагдах эрсдэлтэй машин хэрэгсэлд хамгаалалтын хаалт байрлуулна.
- Галын хор, анхны тусламжийн хайрцгийг нүдэнд ил газар байрлуулна.
- Ажлын байрны эмх цэгцийг өдөр тутмын амьдралын хэв журам болгоно.

☐ ☐
☐ ☐
☐ ☐

[Ажлын арга барил]

- Эрсдэлтэй ажлыг хоёр хоёроороо баг болж хийнэ.

☐ ☐


10 Халдварт өвчин



[Хачигт халдварт өвчин(SFTS, scrub typhus), мэрэгч амьтдын халдварт өвчин]

- Арьсыг аль болох ил гаргахгүй байх. Хамгаалалтын хувцас, малгай, хүзүүний алчуур, толгойн боолт, бээлий, оймс, урт түрийтэй гутал бүгдийг өмсөнө. ☐ ☒
- Ажлын хувцасны хүзүү, ханцуй хэсгийг сайтар дарж бооно. Өмдний шуумгийг оймсоор дарж өмсөнө. ☐ ☒
- Ажлаа эхлэхээс өмнө хачиг зайлуулагч бодисыг хангалттай сайн цацна. ☐ ☒
- Өвсөн дээр хэвтэх юм уу хувцсаа өвсөн дээр тайлж тавьж болохгүй. ☐ ☒
- Ажлаа дуусгаад шүүд шүршүүрт орно. ☐ ☒
- Ажлын хувцсыг энгийн хувцаснаас тусад нь ангилж угаана. ☐ ☒



[Зооноотик өвчин]

- Хээл хаясан болон төллөсөн малын хог зүлбадсыг устгахдаа амны хаалт, хамгаалалтын хувцас, ус нэвтэрдэггүй хамгаалалтын бээлий, хормогч, урт түрийтэй гутал зэрэг хамгаалалтын хэрэгсэл хэрэглэнэ. ☐ ☒
- Гутлаа маш сайн цэвэрлэнэ. ☐ ☒
- Ажлын дундуур юм идэж, ус ууж болохгүй. ☐ ☒
- Эмчид тогтмол үзүүлж эрүүл мэндээ тогтмол хянана. ☐ ☒



✖ Илүү дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзээрэй





농작업 안전 자가점검 체크리스트 (몽골어)

ХАА-н хөдөлмөрийн аюулгүй байдал Өөрийгөө шалгах хуудас

Agricultural Safety Division, Extension Service Bureau, Rural Development Administration
Safety & Disaster Prevention Engineering Division, National Institute of Agricultural Sciences,
Rural Development Administration

300, Nongsaengmyeong-ro, Deokjin-gu, Jeonju, Jeollabuk-do, Rep. of Korea, 54875

Tel. 063-238-1032